



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/216

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас зарласан 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн зорилт, аймгийн "Хариуцлагатай тунгалаг төр" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор хэвлэл мэдээллийн ажилтнуудын ажлын хэрэгцээнд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах зардалд зориулж 1 800 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай..

2. Зардалд зарцуулагдах 1 800 000 төгрөг /Нэг сая найман зуун мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр арга хэмжээний 5.35-д тусгагдсан "Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
04 дүгээр сарын 04-ний өдрийн
А/216 дугаар захирамжийн хавсралт



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

| № | Нэр | Тоо ширхэг | Эвдрэл, гэмтэл |
|---|--------------------|------------|----------------|
| 1 | Зайны микрофон | 1 | Эвдэрсэн |
| 2 | Баттерей цэнэглэгч | 1 | 30000 |

ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

| | Нэр | Тоо ширхэг | Үнэ |
|---|--------------------|------------|------------------|
| 1 | Зайны микрофон | 1 | 1,710,000 төгрөг |
| 2 | Баттерей цэнэглэгч | 1 | 30000 |
| 3 | Нийт дүн | | 1 810 000 төгрөг |

-oOo-